

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД
СУРАЛЦАГЧИД СУРАЛЦАГЧИЙН ТЭТГЭЛЭГ
ОЛГОХ ЖУРАМ**

1. Нийтлэг үндэслэл

1.1. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.6-д заасны дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын диплом, бакалавр, магистр, докторын боловсрол эзэмших өдрийн ангид болон хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүй суралцаж байгаа Монгол Улсын иргэн, хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэнд тус тус сургалтын төлбөр, суралцагчийн тэтгэлэг, санхүүгийн дэмжлэгийг (цаашид "тэтгэлэг" гэх) олгоход энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Үндэсний тэтгэлэг

2.1. Суралцагчид тэтгэлэг олгох дээд боловсролын сургалтын байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар аттестатчилагдсан байх;

2.1.2. нийт төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг төгссөнөөс хойш хагас жил, жилээр гаргаж хэвшсэн байх;

2.1.3. төгсөгчдийн судалгаагаар тэтгэлэг олгогдохоос 2 жилийн өмнөх төгсөгчдийн 30 хувь нь мэргэжлээрээ ажлын байраар хангагдсан байх;

2.1.4. оюутны үйлчилгээ, төгсөгчидтэй ажиллах бүтэцтэй байх;

2.1.5. удирдлагын мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлсэн байх;

2.1.6. сургуулийн нэрэмжит тэтгэлэг олгодог байх.

2.2. Дараах шаардлагыг хангасан диплом, бакалаврын хөтөлбөрийн суралцагчид үндэсний тэтгэлэг олгоно:

2.2.1. элсэлтийн журмын шаардлагыг ханган элссэн өдрийн ангийн суралцагч байх;

2.2.2. хичээлийн жилийн нэг улиралд 12-оос доошгүй багц цагийн хичээл судалж, дүгнүүлсэн байх;

2.2.3 Хичээлийн жилийн өмнөх улирлын голч дүн нь 3.0-аас доошгүй үнэлэгдсэн байх. /ЗГ-ын 2014-7-4-ний өдрийн 214, ЗГ-ын 2015-1-26-ны өдрийн 26-р тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон/

2.3. Дараах шаардлагыг хангасан магистр, докторын хөтөлбөрт суралцагчид үндэсний тэтгэлэг олгоно:

2.3.1. магистрын хөтөлбөрт шинээр элсэгчийн бакалаврын дипломын голч дүн нь 3.2-оос доошгүй байх; /ЗГ-ын 2015-1-26-ны өдрийн 26-р тогтоолоор өөрчлөлт орсон/

2.3.2. докторын хөтөлбөрт шинээр элсэгчийн магистрын дипломын голч дүн нь 3.5-аас доошгүй байх; /ЗГ-ын 2015-1-26-ны өдрийн 26-р тогтоолоор өөрчлөлт орсон/

2.3.3. хичээлийн жилийн нэг улиралд 10-аас доошгүй багц цагийн хичээл судалж, дүгнүүлсэн байх.

2.4. Үндэсний тэтгэлгийг нэг хичээлийн жилд 10 хүртэлх сарын турш олгоно. Тэтгэлэг олгох нийт хугацаа нь тухайн мэргэжлийн сургалтын хөтөлбөрт заасан жилээс хэтрэхгүй байна.

3. Урамшууллын тэтгэлэг (Энэ хэсгийг Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон)

~~3.1. Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад сурлагын ондор амжилт гарган суралцаж байгаа болон тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлээр өдрийн ангид амжилттай суралцаж байгаа суралцагчид урамшууллын тэтгэлэг олгоно.~~

~~3.2. Тусгай шаардлага хангасан суралцагчид урамшууллын тэтгэлгийг үндэсний тэтгэлгийн хэмжээнээс хувиар тооцон нэмж олгоно.~~

~~3.3. Тухайн улирлын урамшууллын тэтгэлгийг өмнөх улирлын голч дүнг харгалзан олгоно.~~

~~3.4. Дараах тусгай шаардлагыг хангасан диплом, бакалаврын хөтөлбөрт суралцагчид урамшууллын тэтгэлэг олгоно:~~

~~3.4.1. энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлээр элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж нь 720-иос дээш оноотой шинээр элсэгчид, 3.6 болон түүнээс дээш голч дүнтэй суралцагчид 50 хувийн; /ЗГ-ын 2015-1-26-ны өдрийн 26-р тогтоолоор өөрчлөлт орсон/~~

~~3.4.2. 3.8 болон түүнээс дээш голч дүнтэй суралцаж байгаа суралцагчид 75 хувийн;~~

~~3.4.3. боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр зохион байгуулсан улсын олимпиадад эхний гурван байрт шалгарсан, олон улсын олимпиадад шагналт байр эзэлсэн шинээр элсэгчид эхний хичээлийн жилд 100 хувийн.~~

~~3.5. Дараах тусгай шаардлагыг хангасан магистр, докторын хөтөлбөрт суралцагчид урамшууллын тэтгэлэг олгоно:~~

~~3.5.1. 3.8 аас дээш голч дүнтэй суралцсан өдрийн ангийн магистрант, докторантад 75 хувийн; /ЗГ-ын 2015-1-26-ны өдрийн 26-р тогтоолоор өөрчлөлт орсон/~~

~~3.5.2. хондлонгийн хянан магадлагаа бүхий олон улсын мэргэжлийн сэтгүүлд нэгээс доошгүй өгүүлэл хэвлүүлсэн магистрант, докторантад 100 хувийн;~~

~~3.6. Урамшууллын тэтгэлгийг давхардуулан олгохгүй.~~

4. Сургалтын төлбөр болон амьжиргааны зардал

4.1. Дараах суралцагчид сургалтын төлбөр олгоно:

4.1.1. бүтэн өнчин суралцагч;

4.1.2. бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагч эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрийн суралцагч; (Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

4.1.3. хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын хөтөлбөрийн нэг суралцагч;

4.1.4. хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэн;

4.1.5. төрийн өмчийн их, дээд сургуульд багш мэргэжлээр элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийг 70 хувь, 751-ээс дээш оноо авсан бол сургалтын төлбөрийг 100 хувь хичээлийн жилийн эхний улиралд; суралцагч 3.0 болон түүнээс дээш голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийг үргэлжлүүлэн 100 хувь; (Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

4.1.6. нэг өрхийн 3 болон түүнээс дээш хүүхэд дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын зэргийн боловсрол эзэмшихээр зэрэг суралцаж байгаа тохиолдолд 1 хүүхдийн. (Энэ заалтыг Засгийн газрын 2016-10-5-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор нэмсэн)

4.1.7. энэ журмын 4.1.1, 4.1.3, 4.1.6-д заасан суралцагчийн өмнөх улирлын голч дүн 2.0 болон түүнээс дээш үнэлэгдсэн тохиолдолд сургалтын төлбөрийг үргэлжлүүлэн; (Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоолоор нэмсэн бөгөөд энэ заалтыг 2018-5-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Мөн Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

4.1.8. цаатан өрхийн бакалаврын хөтөлбөрт суралцагч; (Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор нэмсэн)

4.1.9. төрийн өмчийн болон төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр дээд боловсролын дипломын болон бакалаврын хөтөлбөрт элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтын 501-ээс дээш оноо авсан бол хичээлийн жилийн эхний улирлын сургалтын төлбөрийг 100 хувь; суралцагч 2.5-3.0 хүртэл голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийн 70 хувийг, 3.0 болон түүнээс дээш голч оноотой суралцсан тохиолдолд 100 хувь. *(Энэ дэд заалтыг Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор нэмсэн бөгөөд Засгийн газрын 2021 оны 13 дугаар тогтоолоор нэмэлт орсон. Мөн ЭЕШ-ын 501-ээс дээш оноог 2020-2021 оны хичээлийн жилд 450-иас дээш байхаар тооцсон)*

4.2. Дараах суралцагчид амьжиргааны зардал олгоно:

4.2.1. хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүй суралцаж байгаа Монгол Улсын иргэн;

4.2.2. хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэн;

4.2.3 багш бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуульд амжилттай суралцаж байгаа хөдөө, орон нутагт багшлах дадлага гүйцэтгэх суралцагчид тухайн сургуулийн нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 30 хувьтай тэнцэх хэмжээний амьжиргааны зардал.

4.3. Сургалтын төлбөр, амьжиргааны зардлын хэмжээг Боловсролын болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

4.4. Боловсролын зээлийн сан нь сургалтын төлбөр болон амьжиргааны зардал авах суралцагчтай гэрээ байгуулна. Энэхүү гэрээний загварыг Боловсролын болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. *(Энэ дэд заалтад Засгийн газрын 2016-10-5-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)*

5. Бүрдүүлэх бичиг баримт

5.1.Тэтгэлэгт хамрагдах суралцагч нь дараах баримт бичгийг бүрдүүлэн суралцаж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагад өгнө:

5.1.1. элсэлтийн ерөнхий шалгалтын батламж (шинээр элсэгч);

5.1.2. боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас олгосон суралцах эрхийн бичиг;

5.1.3. энэхүү журмын 4.1 дэх хэсэгт заасан суралцагчийн хувьд эрх бүхий этгээдийн баталгаажуулсан холбогдох баримт бичиг, тодорхойлолт;

5.1.4. энэхүү журмын 4.2.1, 4.2.2. дахь хэсэгт заасан суралцагчийн хувьд боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр.

6. Санхүүжилт

6.1. Дээд боловсролын сургалтын байгууллага нь үндэсний ~~болон урамшууллын~~ тэтгэлэг авах шаардлага хангасан суралцагчийн голч дүн, баримт бичгийг хянаж, тухайн сургуулийн оюутны байгууллагатай зөвшилцөн, тэтгэлэг олгох тухай хүсэлтээ улирал бүр Боловсролын зээлийн санд хүргүүлнэ. (Засгийн газрын 2016-10-5-ны өдрийн 111 дүгээр тогтоол, Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор тус тус өөрчлөлт орсон)

6.2. Боловсролын зээлийн сан нь дээд боловсролын сургалтын байгууллагаас ирүүлсэн тэтгэлэг олгох тухай мэдээллийг хянан магадласны үндсэн дээр үндэсний ~~болон урамшууллын~~ тэтгэлгийг сар бүр тооцож, улирал тутам суралцагчийн дансанд шилжүүлнэ. (Засгийн газрын 2016-10-5-ны өдрийн 111 дүгээр тогтоол, Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор тус тус өөрчлөлт орсон)

6.3. Үндэсний ~~болон урамшууллын~~ тэтгэлэг авсан суралцагч чөлөө авсан эсхүл энэхүү журамд заасан голч дүнгийн шаардлагыг хангаагүй тохиолдолд санхүүжилтийг зогсооно. (Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

6.4. Сурлагын голч дүнгийн шаардлага хангаагүйгээс үндэсний ~~болон урамшууллын~~ тэтгэлгийг нь зогсоосон суралцагч дараагийн улиралд голч дүнгийн шаардлага хангавал тэтгэлгийг үргэлжлүүлэн олгоно. (Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

6.5. Энэхүү журмын 4.2.1 дэх хэсэгт заасан суралцагчийн амьжиргааны зардлыг Монгол Улсаас тухайн оронд суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан олгоно. Дипломат төлөөлөгчийн газар нь өөрийн суугаа болон хавсран суугаа оронд суралцаж байгаа Монгол Улсын иргэний сурлагын дүнгийн талаархи мэдээллийг жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Боловсролын зээлийн санд хүргүүлнэ. /ЗГ-ын 2016-10-5-ны өдрийн 111-р тогтоолоор өөрчлөлт орсон/

6.6. Энэхүү журмын 4.1.4, 4.2.2 дахь хэсэгт заасан суралцагчид сургалтын төлбөр, амьжиргааны зардлыг тухайн хэлэлцээрт заасан нөхцөлийн дагуу олгоно:

6.6.1. суралцагчид олгох тэтгэлгийн хэмжээг холбогдох хэлэлцээрт тодорхой заагаагүй бол боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан шийдвэрээр тогтооно;

6.6.2. дээд боловсролын сургалтын байгууллага нь тухайн суралцагчийн голч дүн, хичээлийн ирц, дотоод дүрэм журмын шаардлагыг хангасан тухай мэдээллийг хичээлийн жилийн улирал бүр Боловсролын зээлийн санд хүргүүлнэ; /ЗГ-ын 2016-10-5-ны өдрийн 111-р тогтоолоор өөрчлөлт орсон/

6.6.3. Боловсролын зээлийн сан нь дээд боловсролын сургалтын байгууллагаас ирүүлсэн суралцагчийн мэдээллийг хянан магадласны үндсэн дээр сургалтын төлбөр, амьжиргааны зардлыг суралцаж байгаа сургалтын байгууллагад нь шилжүүлнэ. /ЗГ-ын 2016-10-5-ны өдрийн 111-р тогтоолоор өөрчлөлт орсон/

7. Бусад

7.1. Сургалтын байгууллага нь суралцагчийн тэтгэлгийн асуудлаар хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, суралцагчийн мэдээллийг удаа дараа буруу гаргасан буюу сурлагын үнэлгээг бодитой бус үнэлсэн нь тогтоогдвол хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ. /Энэ хэсгийн заалтыг ЗГ-ын 2015-1-26-ны өдрийн 26-р тогтоолоор өөрчилсөн/

7.2. Энэхүү журам нь хоёр дахь удаагаа бакалавр, магистр, докторын хөтөлбөрт хамрагдаж байгаа суралцагчид хамаарахгүй.

7.3. Сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг санхүүжүүлэх гэрээ, санхүүжилттэй холбогдон гарсан маргааныг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулна.

---oOo---

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ОЮУТАН, СУРАЛЦАГЧИД ОЮУТНЫ ХӨГЖЛИЙН ЗЭЭЛ ОЛГОХ, ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид “сургууль” гэх)-ын оюутан, суралцагчид “Оюутны хөгжлийн зээл” (цаашид “зээл” гэх) олгох, эргэн төлүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Оюутны хөгжлийн зээлийн зорилго нь оюутан, суралцагчид сургалтын төлбөрийн дарамтгүй суралцах боломжийг бүрдүүлэх, сургуулийн сургалтын үйл ажиллагааны чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино.

1.3.Энэхүү журам нь сургуульд анх удаа бакалавр, магистр болон докторын шатлалд суралцаж байгаа Монгол Улсын иргэнд хамаарна.

1.4.Тухайн жил батлагдсан төсөв болон зээлийн санхүүжилтэд багтаан зээл авах оюутан, суралцагчийн (цаашид “зээлдэгч” гэх) хяналтын тоог боловсролын шатлал, хөтөлбөр, сургууль тус бүрээр төрийн захиргааны төв байгууллагуудын саналыг харгалзан боловсрол болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан тушаалаар жил бүрийн 2 дугаар сарын 10-ны өдрөөс өмнө тогтооно. (Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

1.5.Зээл авах оюутан, суралцагчийн хяналтын тоог (цаашид “хяналтын тоо” гэх) тогтоохдоо Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжил болон төгсөгчдийн сүүлийн 4 жилийн хөдөлмөр эрхлэлтийн хувийг харгалзана. (Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

Хоёр. Зээл олгох үйл ажиллагаа, эргэн төлөлт, санхүүжилт

2.1.Энэхүү журамд заасан шаардлагыг хангасан зээлд хамрагдах суралцагчтай Боловсролын зээлийн сан (цаашид “сан” гэх) зээлийн гэрээ байгуулна.

2.2.Сан, оюутан, суралцагчдын хооронд байгуулах оюутны зээлийн гэрээний болон сан, сургуулийн хамтран ажиллах гэрээний загварыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.3.Сан нь оюутан, суралцагчид хичээлийн жилийн тухайн улиралд сонгосон багц цагийн төлбөртэй тэнцэх хэмжээний зээлийг суралцаж байгаа сургуулиар дамжуулан олгоно.

2.4.Бакалаврын шатлалд суралцаж байгаа зээлдэгчийн өмнөх улирлын голч дүн 2.8 болон түүнээс дээш, магистрант, докторантурт суралцаж байгаа зээлдэгчийн өмнөх улирлын голч дүн 3.2 болон түүнээс дээш байх тохиолдолд зээлийг үргэлжлүүлэн олгоно.

2.5.Зээл олгох нийт хугацаа тухайн мэргэжлийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд заасан хугацаанаас хэтрэхгүй байна. Зээлдэгч хичээлийн жилийн нэг улиралд 10-аас доошгүй багц цагийн хичээл судалж, дүгнүүлсэн байна. Хангалтгүй үнэлгээ авсан хичээлийг давтан суралцсан тохиолдолд тухайн багц цагийн хичээлийн төлбөрт зориулан дахин зээл олгохгүй.

2.6.Зээлдэгч чөлөө авсан, өөр сургуульд шилжсэн болон бусад шалтгаанаар зээлийн гэрээг сунгах боломжгүй болсон тохиолдолд энэхүү журмын 5.4.2-т заасан хугацаанд суралцаж байгаа сургуульдаа мэдэгдэнэ. Уг мэдээллийг уламжилсан сургуулийн албан ёсны саналыг үндэслэн сан санхүүжилтийг түр зогсооно. Зээлдэгч сургуулиас гарсан, эсхүл хасагдсан тохиолдолд зээлийг эргэн төлүүлнэ.

2.7.Зээлдэгч сургууль төгсч диплом авсан өдрөөс эхлэн 6 хүртэлх жилийн дотор зээлийг төлж дууссан байхаар эргэн төлөлтийн хуваарийг гаргаж, зээлийн гэрээнд тодорхой тусгана.

2.8.Орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчийн зээлийг эргэн төлөх хугацааг 2 жил хүртэлх хугацаагаар сунгаж болно.

2.9.Зээлдэгч зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хуваарийн дагуу Төрийн сан дахь Боловсролын зээлийн сангийн дансанд хийнэ.

2.10.Зээлийн гэрээнд зээлдэгчийн эрх, үүрэг, хариуцлага, зээлийн хэмжээ, эргэн төлөх нөхцөлийг тодорхой тусгана.

Гурав. Сангийн эрхлэх үйл ажиллагаа

3.1.Сан нь зээл олгох, санхүүжүүлэх, эргэн төлүүлэх чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

3.1.1.эрсдэлийг бууруулах зорилгоор даатгалын байгууллага, зээл төлүүлэх арга хэмжээний хүрээнд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

3.1.2.хяналтын тоог батлагдсан өдрөөс эхлэн 14 хоногийн дотор хяналтын тооны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлэх;

3.1.3.хяналтын тоог батлагдсан өдрөөс эхлэн 14 хоногийн дотор тухайн сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулан түүний биелэлтийг хангаж ажиллах;

3.1.4.зээлдэгчийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлэх;

3.1.5.сан нь зээлдэгч сургалтын хөтөлбөрийг зогсоосон талаар мэдээлэл авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор зээлийн санхүүжилтийг түр зогсоох.

3.2.Нас барсан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсаны улмаас суралцах боломжгүй болсон зээлдэгчийн зээлийн гэрээг дуусгавар болгох, зээлийн төлбөрөөс бүрэн чөлөөлөх асуудлыг сан шийдвэрлэнэ.

Дөрөв. Сургуулийн эрхлэх үйл ажиллагаа, зээлдэгчийн сонгон шалгаруулалт

4.1.Сургууль зээл олгох ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

4.1.1.сантай хамтран ажиллах гэрээ байгуулсан өдрөөс эхлэн 14 хоногийн дотор оюутан, суралцагчид зээлийн нөхцөл, хяналтын тооны талаар мэдээлэх ажлыг зохион байгуулах;

4.1.2.зээлд хамрагдах оюутан, суралцагчийг сонгон шалгаруулах комиссыг оюутны төлөөллийг оролцуулан 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулах;

4.1.3.зээлийн 5 хувьтай тэнцэх хэмжээгээр “Зээлийн эрсдэлийн сан” бүрдүүлж, зээлийн гэрээний гүйцэтгэлийг дүгнэх;

4.1.4.зээлд хамрагдсан төгсөгчдөд оюутны үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан нэгжээр дамжуулан ажлын байр олоход дэмжлэг үзүүлэх;

4.1.5.сантай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хангаж ажиллах.

4.2.Сонгон шалгаруулах комисс зээлийн шаардлага хангасан, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн оюутан, суралцагчийг зээлд тэргүүн ээлжид хамруулах чиглэл баримтална.

4.3.Сонгон шалгаруулах комисс зээлд хамрагдах хүсэлтэй оюутан, суралцагчийг шалгаруулахдаа энэхүү журмын 5.1-д заасан шалгуураас гадна тухайн оюутан, суралцагчийн боловсролын түвшинг үнэлэх бусад нэмэлт шалгуурыг харгалзан үзнэ.

4.4.Сургууль нь хяналтын тоонд багтаан зээлийн шаардлага хангасан оюутан, суралцагчдыг зээлд хамруулах саналаа захирлын тушаалаар баталгаажуулан холбогдох мэдээллийн хамт санд жил бүрийн 10 дугаар сарын 1-ний болон 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ. (Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор нэмэлт орсон)

4.5.Сургууль нь зээлдэгч сургуулиас гарах, шилжих, чөлөө авахаар өргөдөл гаргасан болон хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 30 болон түүнээс дээш хоног хичээл тасалсан тохиолдолд санд нэн даруй бичгээр хүргүүлж, мэдээллийн санд бүртгэн зээлийн үлдэгдлийг эргүүлэн шилжүүлэх арга хэмжээ авна.

4.6.Сургууль зээлдэгчийн шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг зээлийн мэдээллийн системд бүртгэснээс хойш ажлын 10 хоногийн дотор санд албан бичгээр хүргүүлнэ.

Сургууль энэ тухай мэдэгдээгүй тохиолдолд тухайн зээлийг өөрөө бүрэн хариуцаж, зээлийг зээлийн эрсдэлийн сангаас санд буцаан төвлөрүүлнэ.

4.7.Сургууль нь энэхүү журмын 4.6-д заасан үүргээ хэрэгжүүлээгүйгээс үүссэн аливаа эрсдэлийг бүрэн хариуцна.

4.8.Зээлийн эрсдэлийн сангийн үйл ажиллагааны талаар сан болон сургуулийн хамтран ажиллах гэрээнд тодорхой тусгана.

Тав. Зээлдэгчид тавих шаардлага, эрх, үүрэг

5.1.Зээл хүсэгч нь дараах шаардлагыг хангасан байна:

5.1.1.элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж 600 болон түүнээс дээш оноо авсан элсэгч байх;

5.1.2.голч дүн 2.8 болон түүнээс дээш оноотой суралцаж байгаа бакалаврын шатлалын оюутан байх;

5.1.3.голч дүн 3.2 болон түүнээс дээш голч дүнтэй суралцаж байгаа магистрант, докторант байх;

5.1.4.сангийн мэдээллийн системд бүртгэгдсэн байх;

5.1.5. цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан элсэлтийн ерөнхий шалгалтад 500 болон түүнээс дээш оноо авсан элсэгч байх. (Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор нэмсэн)

5.2.Энэхүү журмын 5.1-д заасан шаардлагыг хангасан оюутан, суралцагч өөрийн суралцаж байгаа сургуулиараа дамжуулан зээл авах хүсэлтийг санд гаргана.

5.3.Зээл хүсэгч хүсэлт гаргахдаа дараах материалыг бүрдүүлнэ:

5.3.1.иргэний үнэмлэхийн хуулбар;

5.3.2.зээл хүссэн, эргэн төлөхөө илэрхийлсэн өргөдөл;

5.3.3.элсэлтийн ерөнхий шалгалтийн онооны хуудасны хуулбар;

5.3.4.сургуулийн голч дүнг тусгасан тодорхойлолт;

5.3.5.төлбөрийн нэхэмжлэхийн эх хувь;

5.3.6.тухайн улиралд судалж байгаа хичээлийн баталгаажуулсан жагсаалт;

5.3.7.ирээдүйн зорилгоо тодорхойлох эссэ (зээлд хамрагдсанаар нийгэмд үзүүлэх хувь нэмэр, тухайн мэргэжлээр суралцсанаар ямар үр дүнд хүрэх талаарх).

5.4.Зээлдэгч дараах эрх, үүрэгтэй байна:

5.4.1.өөрийн талаарх үнэн зөв, бодит байдалд нийцсэн бүрэн мэдээлэл өгөх, хувийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд нэн даруй сургуулийн сургалтын албанд мэдэгдэх;

5.4.2.эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар чөлөө авсан, өөр сургуульд шилжсэн, хасагдсан, цаашид суралцах боломжгүй болсон тохиолдолд 14 хоногийн дотор сургуулийн сургалтын албанд мэдэгдэх;

5.4.3.Боловсролын тухай хуулийн 45.1.6-д заасны дагуу сургууль төгссөний дараа ажил эрхэлсний болон ирээдүйн бусад орлогоосоо зээлийн эргэн төлөлтийг бүрэн хариуцах;

5.4.4.зээлийн гэрээний хугацааг дуусах хүртэлх хугацаанд зээлээ төлөх, ажилд орсон, ажлаа өөрчилсөн тохиолдолд энэ талаарх мэдээллийг тухай бүр санд мэдэгдэх.

Зургаа. Бусад

6.1.Зээлийн сангийн хөрөнгийн эргэн төлөлт, зарцуулалт, тайлагналд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, сангийн удирдах зөвлөл хяналт тавих бөгөөд зээлийн үйл ажиллагааны тайланг улирал бүр хүлээн авч дүгнэнэ.

6.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай тохиолдолд зээлийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, ашиглалтад хяналт тавина.

6.3.Зээлдэгч энэхүү журам, зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй болон зээлийн гэрээтэй холбоотой маргаан үүссэн тохиолдолд асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.4.Сургууль нь зээлдэгчийн асуудлаар хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, зээлдэгчийн мэдээллийг буруу гаргаж ирүүлсэн нь хууль хяналтын байгууллагаар тогтоогдвол сургуулийн удирдлага, холбогдох албан тушаалтан хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ. (Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)